



## ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

### ДОРНОД АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ /ДОА-2019/01/-СТА-ТЕЗ/



**ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТӨӨС ШАЛТГААЛЖ ТЕЗ-ИЙН 2018 ОНЫ  
ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮР ДҮН ЗОРИЛТОТ ТҮВШИНД БҮРЭН ХҮРЭЭГҮЙ БАЙНА.**

Чойбалсан хот

2019 он



**Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн  
2018 оны төсвийн гүйцэтгэл**

**АГУУЛГА**

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**

**I Бүлэг. Аймгийн 2018 оны төсвийг үр дүнтэй төлөвлөөгүй байна.**

1.1. Аймгийн 2018 оны төсөвт Тусламжийн орлогыг бодитой төлөвлөөгүй байна.

1.2. Аймгийн 2018 оны төсөвт хуульд нийцэхгүй төсөл арга, хэмжээг төлөвлөн баталсан байна.

**II Бүлэг. Төсвийн гүйцэтгэлийн үр дүн хангалтгүй байна.**

2.1. Аймгийн төсвийн 2018 оны нийт орлогын төлөвлөгөө биелсэн боловч тусламжийн орлого 61.3 хувиар тасарсан байна.

2.2. Төсвийн нийт зардлыг 185,4 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

2.3. Төсвийг зарцуулахдаа Төсвийн болон ТБОНӨХБАҮХА тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.4. Нэмэлт төсвийг захиран зарцуулахдаа төсвийн тухай хууль болон холбогдох хууль журмыг мөрдөж ажиллаагүй байна.

**III Бүлэг. Тухайн жилд хүрэх зорилтот түвшин бүрэн хангагдаагүй байна.**

3.1. ТЕЗ-ийн хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн биелэлт бүрэн хангагдаагүй байна.

3.2. Хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналт хийгдээгүй байна.

**ДҮГНЭЛТ**  
**ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН ИРҮҮЛСЭН**  
**ХАРИУ**  
**ЗӨВЛӨМЖ**  
**ТУШААЛ**

Тайланг бэлтгэсэн:  
Дорнод аймаг дахь  
Төрийн аудитын газрын  
Санхүүгийн аудитын  
алба

Дарга бөгөөд Тэргүүлэх  
аудиторын албан  
үүргийг түр орлон  
гүйцэтгэгч Ц.Батбаяр  
Утас: 70584203

Хэлтсийн дарга бөгөөд  
аудитын менежер  
В.Цэнгэлмаа  
Утас: 70584204

Ахлах аудитор  
Д.Нармандах,  
Ж.Баяртуул

Аудитор  
М.Ухаанбилэг  
Утас: 70584207

2019 оны 04 дүгээр сар

Аудитын тайлантай  
холбоотой асуудлаар  
нэмж тодруулах, асууж  
лавлах зүйл байвал  
70584207, 70584204  
дугаарын утас болон  
[dornod@audit.gov.mn](mailto:dornod@audit.gov.mn)  
цахим хаягаар  
харилцана уу.

Хаяг: Дорнод аймаг,  
Хэрлэн сум, 7-р баг,  
аймгийн ЗДТГ-ын 2-р байр,  
2 давхар 04 тоот



**ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

|                      |                                                                                             |
|----------------------|---------------------------------------------------------------------------------------------|
| <b>УИХ</b>           | Улсын Их Хурал                                                                              |
| <b>ГА</b>            | Гүйцэтгэлийн аудит                                                                          |
| <b>АДБОУС</b>        | Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт                                            |
| <b>ҮАГ</b>           | Үндэсний аудитын газар                                                                      |
| <b>ЗГ</b>            | Засгийн газар                                                                               |
| <b>ГАГ</b>           | Гүйцэтгэлийн аудитын газар                                                                  |
| <b>МУЕА</b>          | Монгол Улсын Ерөнхий аудитор                                                                |
| <b>ИТХ</b>           | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал                                                                |
| <b>ТЕЗ</b>           | Төсвийн ерөнхийлөн захирагч                                                                 |
| <b>ЗДТГ</b>          | Засаг даргын Тамгын газар                                                                   |
| <b>СС</b>            | Сангийн сайд                                                                                |
| <b>СЯ</b>            | Сангийн яам                                                                                 |
| <b>МХГ</b>           | Мэргэжлийн хяналтын газар                                                                   |
| <b>ОНӨААТҮГ</b>      | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар                                        |
| <b>ТАХ</b>           | Төсөл, арга хэмжээ                                                                          |
| <b>ТБОНӨХБАҮХАТХ</b> | Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль |
| <b>ГИХШХГ</b>        | Гадаадын иргэний харьяа шилжилт хөдөлгөөний газар                                           |
| <b>ДОА</b>           | Дорнод аймаг                                                                                |
| <b>СТА</b>           | Санхүүгийн тайлангийн аудит                                                                 |
| <b>ОНХНС</b>         | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан                                                           |
| <b>ОНХС</b>          | Орон нутгийн хөгжлийн сан                                                                   |



## **Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны төсвийн гүйцэтгэл**

### **Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**

#### **Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

Аудитыг МҮЕА-ын орлогчийн “Үндэсний аудитын газрын 2019 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” 2019 оны А/03 дугаар тушаалыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15.2-т заасны дагуу Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

#### **Аудитын зорилт:**

Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны төсвийн гүйцэтгэлд аудит хийн, дүгнэлт өгч, гарсан зөрчлийг арилгах, цаашид сайжруулах, санал, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

1. Аймгийн 2018 оны төсвийг бодиттой төлөвлөсөн эсэх.
2. Аймгийн 2018 оны төсвийн гүйцэтгэлийг үр дүнтэй хэрэгжүүлсэн эсэх
3. ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн зорилтот түвшинд нийцсэн эсэх.

#### **Аудитын хамрах хүрээ:**

Аудитад аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, Татварын хэлтэс, Санхүү хяналт, аудитын алба хамрагдлаа.

#### **Үндсэн мэдээлэл:**

Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 06 дугаар хуралдааны 10 дугаар тогтоолоор аймгийн 2018 оны төсвийг баталсан байна. Үүнд:

1. Дорнод аймгийн 2018 оны төсвийг 54.9 тэрбум төгрөгөөр баталсан бол ИТХ-ын 2018 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 7 дугаар хуралдаанаар төсөвт тодотгол хийн 1.6 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж, орлого, зарлагыг 56.5 тэрбум төгрөгөөр баталсан байна.
2. Сангийн яамнаас 2017 оны 7 дугаар сарын 08-ны өдөр аймгийн 2018 оны төсвийн жилийн нийт суурь зарлагын хязгаарыг 16,2 тэрбум төгрөгөөр батлан ирүүлсэн байна.

#### **Аудитын арга зүй:**

Аудитыг гүйцэтгэхдээ гүйцэтгэлийн аудитын удирдамж, (АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, журамд заасны дагуу холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, тайлбар, тодруулга, шалгагдагч байгууллагаас авсан судалгаа, мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, анхны баримтаас хөөн шалгах, бодит байдал дээр оршин байгааг үзэх, ажиглалт хийх зэрэг аудитын горимуудыг ашиглав.

#### **Аудитын шалгуур үзүүлэлт:**

- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль,
- Төсвийн тухай хууль,



**Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн  
2018 оны төсвийн гүйцэтгэл**

- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хууль,
- Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”,
- Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”
- Сангийн сайдын 2018 оны 288 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”
- Бусад холбогдох хууль тогтоомж, эрхийн актууд

**Аудит хийх багийн бүрэлдэхүүн:**

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаяр удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер В.Цэнгэлмаа хэрэгжүүлж, гүйцэтгэлийн аудитын албаны ахлах аудитор Д.Нармандах, Ж.Баяртуул, аудитор М.Ухаанбилэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

**Аудитын хугацаа:**

Аудитын талбарын ажлыг 04 дүгээр сарын 05-ны өдрөөс эхлүүлэн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ҮАГ-ын Санхүүгийн аудитын газар болон холбогдох байгууллага, албан тушаалтанд 04 дүгээр сарын 25-ны өдөр хүргүүллээ.

**Аудитын тайлангийн бүтэц түүнд тусгагдах мэдээлэл, хэлэлцүүлэх журам:**

Аудитын тайлан нь оршил хэсэг, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал, түүнд өгсөн тайлбар гэсэн хэсгүүдээс бүрдэх бөгөөд аудитын дэд зорилтын дагуу бичлээ. Аудитын тайлангийн төслийг шалгадагч байгууллагын удирдлагад танилцуулж санал авсан бөгөөд тайлангийн эцсийн хувилбарыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дарга бөгөөд Тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажууллаа.



**Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн  
2018 оны төсвийн гүйцэтгэл**

**I Бүлэг. Аймгийн 2018 оны төсвийг үр дүнтэй төлөвлөөгүй байна.**

ТЕЗ-ийн 2018 оны нийт орлого, зарлагыг 62,093.5 сая төгрөгөөр төлөвлөн баталсан байна. Үүнээс:

- Аймгийн төсвийн орлого, зарлагыг 56,516.8 сая,
- Сумдын төсвийн орлого, зарлагыг 5,576.7 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Аймгийн 2018 оны төсвийг ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 06 дугаар хуралдааны 10 дугаар тогтоолоор 54.9 тэрбум төгрөгөөр баталсныг, 2018 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 7 дугаар хуралдаанаар 1.637,5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 56.5 тэрбум төгрөгөөр тодотгон баталсан байна.

Хүснэгт 1. Тодотгосон төсвийн орлогыг анх батлагдсан дүнтэй харьцуулбал:

/мян.төг/

| № | Орлогын нэр төрөл                 | 2018 оны төсөв       |                      |                     |
|---|-----------------------------------|----------------------|----------------------|---------------------|
|   |                                   | Анхны батлагдсан     | Төсвийн тодотгол     | Зөрүү               |
|   | <b>Аймгийн төсөв</b>              | <b>54 879 298,60</b> | <b>56 516 777,10</b> | <b>1 637 478,50</b> |
|   | <b>Татварын орлого</b>            | <b>13 672 596,10</b> | <b>13 672 596,10</b> | -                   |
|   | Цалин хөлс                        | 9 806 956,10         | 9 806 956,10         | -                   |
|   | Татварын буцаан олголт            | - 910 000,00         | - 910 000,00         | -                   |
|   | Газрын төлбөр                     | 410 000,00           | 410 000,00           | -                   |
|   | Газрын дуудлага худалдааны орлого | 230 000,00           | 230 000,00           | -                   |
|   | ҮХХТатвар                         | 600 000,00           | 600 000,00           | -                   |
|   | АТБӨЯХТатвар                      | 346 100,00           | 346 100,00           | -                   |
|   | Усны нөөц ашигласны төлбөр        | 3 183 540,00         | 3 183 540,00         | -                   |
|   | Газрын ҮХХ                        | 6 000,00             | 6 000,00             | -                   |
|   | <b>Татварын бус</b>               | <b>563 000,00</b>    | <b>681 000,00</b>    | <b>118 000,00</b>   |
|   | Хүү торгууль                      | 470 000,00           | 568 000,00           | 98 000,00           |
|   | Төсөвт газрын өөрийн орлого       | 53 000,00            | 73 000,00            | 20 000,00           |
|   | Бусад нэр заагдаагүй орлого       | 40 000,00            | 40 000,00            | -                   |
|   | <b>Тусламжийн орлого</b>          | <b>39 354 702,50</b> | <b>39 552 559,50</b> | <b>197 857,00</b>   |
|   | Гадаад дотоодын хандив тусламж    | 559 606,00           | 757 463,00           | 197 857,00          |
|   | ОНХС                              | 3 650 421,70         | 3 650 421,70         | -                   |
|   | Тусгай зориулалт                  | 30 553 594,80        | 30 553 594,80        | -                   |
|   | Улсын төсвийн санхүүгийн дэмжлэг  | 4 591 080,00         | 4 591 080,00         | -                   |
|   | <b>Бусад санхүүжилт</b>           | <b>1 289 000,00</b>  | <b>2 610 621,50</b>  | <b>1 321 621,50</b> |
|   | Хэрлэн сумын орлого               | 270 000,00           | 270 000,00           | -                   |
|   | Оны эцсийн үлдэгдэл               | 1 019 000,00         | 2 340 621,50         | 1 321 621,50        |

Хүснэгт 2. Тодотгосон төсвийн зарлагыг анх батлагдсан дүнтэй харьцуулбал:

/мян.төг/

| №  | Зарлагын нэр төрөл                  | 2018 оны төсөв       |                      |                     |
|----|-------------------------------------|----------------------|----------------------|---------------------|
|    |                                     | Анхны батлагдсан     | Төсвийн тодотгол     | Зөрүү               |
| 1  | Аймгийн ИТХ                         | 318 917,80           | 343 817,80           | 24 900,00           |
| 2  | Аймгийн ЗДТГ                        | 1 730 082,10         | 1 700 682,10         | - 29 400,00         |
| 3  | Санхүүгийн хяналт аудитын алба      | 174 125,50           | 174 125,50           | -                   |
| 4  | Байгал орчин аялал жуулчлалын газар | 1 423 894,80         | 1 455 494,80         | 31 600,00           |
| 5  | Орон нутгийн өмчийн газар           | 133 447,90           | 138 447,90           | 5 000,00            |
| 6  | Сум дундын ойн анги                 | 33 592,00            | 40 067,00            | 6 475,00            |
| 7  | Хот тохижуулах                      | 839 219,80           | 955 440,30           | 116 220,50          |
| 8  | Сумдын ЗДТГ                         | 1 014 131,30         | 1 292 871,30         | 278 740,00          |
| 9  | Халамжийн сан                       | 8 962 753,20         | 8 962 753,20         | -                   |
| 10 | Мал хамгаалах сан                   | 60 000,00            | 60 000,00            | -                   |
| 11 | Орон нутгийн хөрөнгө оруулалт       | 1 485 876,00         | 2 437 876,00         | 952 000,00          |
| 12 | ОНХС                                | 4 010 421,70         | 4 262 364,70         | 251 943,00          |
| 13 | Тусгай зориулалтын шилжүүлэг        | 30 553 594,80        | 30 553 594,80        | -                   |
| 14 | Сумдын санхүүгийн дэмжлэг           | 4 139 241,70         | 4 139 241,70         | -                   |
|    | <b>Нийт зардал</b>                  | <b>54 879 298,60</b> | <b>56 516 777,10</b> | <b>1 637 478,50</b> |



**Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн  
2018 оны төсвийн гүйцэтгэл**

Төсвийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2 дахь хэсэгт “Засаг дарга дараах тохиолдолд тухайн жилийн төсвийн тодотголыг боловсруулж, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ” гэж хуульчилсан байна. Үүнд:

1. Дээд шатны төсөвт тодотгол хийсний улмаас тухайн шатны төсөвт тодотгол хийх зайлшгүй тохиолдол бий болсон.
2. Урьдчилан тооцох боломжгүй нөхцөл байдлын улмаас төсвийн орлого буурах, зарлага нэмэгдэж орон нутгийн төсөвт алдагдалтай болох нөхцөл байдал бий болсон.
3. Төсвийн тухай хуулийн 29.7-д заасан үндэслэл бий болсон тохиолдолд батлагдсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төсөвт өртөгт өөрчлөлт оруулах тохиолдол бий үед. /Төсвийн тухай хуулийн 29.7-д “Үйлдвэрлэлийн түүхий эдийн үнийн индекс нь батлагдсан төсөвт тооцсон хэмжээнээс хоёр дахин өссөн тохиолдолд түүнийг тухайн жилийн төсвийн тодотголд тусган өөрчилнө”/

Сумдын 2018 оны нийт төсөв анх 3.8 тэрбум төгрөгөөр батлагдсаныг тодотгол хийн 1,8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

**1.1. Төсвийн орлогын төлөвлөлтийн талаар:**

Аймгийн төсвийн орлогыг төлөвлөхдөө өмнөх оны гүйцэтгэл болон сүүлийн жилүүдийн дундажтай харьцуулан төлөвлөдөг байна. Аймгийн 2018 оны төсөвт нийт орлогын төлөвлөгөөг өмнөх оны төлөвлөгөөнөөс 2,894.3 сая төгрөгөөр нэмж баталсан байна. Үүнээс татварын орлогыг 297,1 сая төгрөг, татварын бус орлогыг 2545.6 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

Хүснэгт 3. Аймгийн 2018 оны төсвийн орлогын төлөвлөлтийн байдал

| №        | Татварын төрөл                    | 2017 он              |                      |                       | 2018 он              | 2017, 2018 онуудын төлөвлөгөөний зөрүү |
|----------|-----------------------------------|----------------------|----------------------|-----------------------|----------------------|----------------------------------------|
|          |                                   | Төлөвлөгөө           | Гүйцэтгэл            | Зөрүү                 | Төлөвлөгөө           |                                        |
|          | <b>Аймгийн төсөв</b>              | <b>53 622 408,30</b> | <b>53 695 585,10</b> | <b>73 176,80</b>      | <b>56 516 777,10</b> | <b>2 894 368,80</b>                    |
| <b>1</b> | <b>Татварын орлого</b>            | <b>13 375 463,80</b> | <b>14 990 988,30</b> | <b>1 615 524,50</b>   | <b>13 672 596,10</b> | <b>297 132,30</b>                      |
|          | Цалин хөлс                        | 8 793 662,90         | 10 215 969,80        | 1 422 306,90          | 9 806 956,10         | 1 013 293,20                           |
|          | Татварын буцаан олголт            | - 902 662,40         | - 903 695,20         | - 1 032,80            | - 910 000,00         | - 7 337,60                             |
|          | Газрын төлбөр                     | 362 808,00           | 448 165,30           | 85 357,30             | 410 000,00           | 47 192,00                              |
|          | Газрын дуудлага худалдааны орлого | 892 655,30           | 437 806,40           | - 454 848,90          | 230 000,00           | - 662 655,30                           |
|          | ҮХХТатвар                         | 480 000,00           | 565 600,30           | 85 600,30             | 600 000,00           | 120 000,00                             |
|          | АТБӨЯХТатвар                      | 325 000,00           | 329 637,70           | 4 637,70              | 346 100,00           | 21 100,00                              |
|          | Усны нөөц ашигласны төлбөр        | 3 420 000,00         | 3 889 452,50         | 469 452,50            | 3 183 540,00         | - 236 460,00                           |
|          | Газрын ҮХХ                        | 4 000,00             | 8 051,50             | 4 051,50              | 6 000,00             | 2 000,00                               |
| <b>2</b> | <b>Татварын бус</b>               | <b>37 687 594,80</b> | <b>36 145 247,10</b> | <b>- 1 542 347,70</b> | <b>40 233 559,50</b> | <b>2 545 964,70</b>                    |
|          | Хүү торгууль                      | 420 000,00           | 625 659,30           | 205 659,30            | 568 000,00           | 148 000,00                             |
|          | Төсөвт газрын өөрийн орлого       | 72 500,00            | 72 500,00            | -                     | 73 000,00            | 500,00                                 |
|          | Бусад нэр заагдаагүй орлого       | 40 000,00            | 40 000,00            | -                     | 40 000,00            | -                                      |
|          | Гадаад дотоодын хандив тусламж    | 1 700 000,00         | -                    | - 1 700 000,00        | 757 463,00           | - 942 537,00                           |
|          | ОНХС                              | 2 084 131,10         | 2 084 131,10         | -                     | 3 650 421,70         | 1 566 290,60                           |
|          | Тусгай зориулалт                  | 30 182 131,00        | 30 134 124,00        | - 48 007,00           | 30 553 594,80        | 371 463,80                             |
|          | Улсын төсвийн санхүүгийн дэмжлэг  | 3 188 832,70         | 3 188 832,70         | -                     | 4 591 080,00         | 1 402 247,30                           |
| <b>3</b> | <b>Бусад санхүүжилт</b>           | <b>2 559 349,70</b>  | <b>2 559 349,70</b>  | <b>0</b>              | <b>2 610 621,50</b>  | <b>51 271,80</b>                       |
|          | Хэрлэн сумын орлого               | 105 837,20           | 105 837,20           | -                     | 270 000,00           | 164 162,80                             |
|          | Оны эцсийн үлдэгдэл               | 2 453 512,50         | 2 453 512,50         | -                     | 2 340 621,50         | - 112 891,00                           |

**1.1.1. Татварын орлогын талаар:**

Татварын орлогын өөрчлөлтийг нэр төрлөөр авч үзвэл:

1. Хувь хүний орлогын албан татвар, газрын төлбөр, үл хөдлөх хөрөнгийн татвар,



## Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны төсвийн гүйцэтгэл

авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн татвар, газрын үл хөдлөх хөрөнгийн татваруудыг нийт 1.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн нь өмнөх оны гүйцэтгэлээр давсан дүнгийн 75 хувьтай тэнцүү байна. Тухайн төрлийн татварын орлогын өсөлт нь татварын суурь нэмэгдсэнтэй холбоотой байгаа тул нэмэгдүүлэн төлөвлөсөн нь үндэслэлтэй байна.

2. Өмнөх оноос газрын дуудлага худалдааны орлогыг 662.6 сая, усны нөөц ашигласны төлбөрийн орлогыг 236.5 сая төгрөгөөр тус тус бууруулан баталсан нь усны нөөц ашигласны төлбөрийн хувьд газрын гүний усны ашиглалтыг бууруулах орон нутгийн бодлого шийдвэр, холимог металлын олборлолт явуулдаг “Шинь Шинь” компанийн үйл ажиллагааг байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллөөс шалтгаалан зогсоож болзошгүй нөхцөл байдал үүссэн, газрын дуудлага худалдааны орлогын хувьд өмнөх онд хэт өндөр төлөвлөснөөс 454.8 сая төгрөгөөр төсвийн орлого тасарсан зэргээс шалтгаалсан байна.

Сумдын 2018 оны төсвийн нийт орлогыг 5,576.7 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

График 1.



1. Сумдаас Хэрлэн сум нь улсын тэмдэгтийн хураамжийг 2018 онд 1.5 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 1.0 тэрбум төгрөгийг гадаадын иргэн, харьяалалгүй хүнд зөвшөөрөл, виз олгохтой холбоотой тэмдэгтийн хураамжаас төвлөрүүлэхээр баталсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 23.8-д заасан сумын төсвийн татварын орлогод хамаарахгүй байгаа бөгөөд 23.4.9-д улсын төсөвт төвлөрүүлэхээр заасан байна. Холбогдох албан тушаалтнаас сумын төсөвт төвлөрүүлэхээр тооцсон шалтгааныг тодруулахад Хэрлэн сумын Засаг дарга, ГИХШХЕГ-ын даргатай бичгээр хийгдсэн гэрээ аман хэлцэлд үндэслэн тус орлогыг төлөвлөсөн байна.
2. Сумдын Засаг дарга нар нь Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор баталсан “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 3.5.7-д<sup>1</sup> заасны дагуу сангийн орлогыг төсвийн орлогын төлөвлөгөөнд тусган батлуулаагүй байна.

### 1.1.2. Татварын бус орлогын талаар:

Татварын бус орлогын өөрчлөлтийг нэр төрлөөр нь авч үзвэл:

<sup>1</sup> “сангаас олгосон зээлийн хүүгийн тухайн жилийн орлогыг зарцуулах саналыг энэ журмын 1.8-д заасны дагуу боловсруулж, жил бүрийн сумын төсөвтэй хамт иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулах”



## Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны төсвийн гүйцэтгэл

1. Улсын төсвөөс олгосон шилжүүлгийн орлого өмнөх оноос 3340.0 сая төгрөгөөр өссөн байна. Хүү торгуулийн орлого, төсөвт байгууллагын өөрийн орлого, Хэрлэн сумын төсвийн орлогын тэнцлийн ашгаас төвлөрүүлэх орлогуудыг 269.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.
2. Тусламжийн орлогыг өмнөх оноос 942.5 сая төгрөгөөр бууруулсан хэдий ч уг орлогыг газрын тосны хайгуулын зөвшөөрөл бүхий 5 компаниас төвлөрүүлэхээр тооцсон ч албан ёсоор байгуулсан гэрээ хэлэлцээр байхгүй байна. Өмнөх онд 1.7 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн нь 100 хувь тасарсан байна.

Төрийн аудитын газраас “Аймгийн 2018 оны орон нутгийн төсөв”-ийн төсөлд эх үүсвэр тодорхойгүй 1.0 тэрбум төгрөгийн тусламжийн орлогыг бууруулах тухай саналыг өгсөн ч 0.3 тэрбумаар бууруулж 0.7 тэрбумыг нь хэвээр баталсан байна.

### 1.2. Төсвийн зарлагын төлөвлөлтийн талаар:

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Сангийн яамнаас хянан ирүүлсэн хязгаарт багтаан тухайн жилийн төсвийн төслийг боловсруулан ИТХ-аар батлуулахаар Төсвийн тухай хуулийн 31.1.3-т заасан байна.

Сангийн яам нь аймгийн 2018 оны төсвийн жилийн суурь орлогын хязгаарыг 21.7 тэрбум, суурь зарлагын хязгаарыг 17.2 тэрбум төгрөгөөр 2017 оны 7 дугаар сарын 08-ны өдөр хянан ирүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 4.1.8 дахь хэсэгт “жилийн төсвийн хязгаар” нь төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээг” хэлнэ гэж заасан байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн суурь зардлыг жилийн төсвийн хязгаараас 1,459.7 сая төгрөгөөр хэтрүүлэн төлөвлөж батлуулсан байна.

### Хүснэгт 4. Аймгийн ИТХ-аар батлагдсан 2018 оны төсөв болон Сангийн яамны баталсан хязгаарын харьцуулалт

/мян.төг/

| №  | Мэргэжилтэн/ байгууллагын нэр            | 2018 он              |                      |                      |                     |
|----|------------------------------------------|----------------------|----------------------|----------------------|---------------------|
|    |                                          | Хязгаар              | Хянасан              | ИТХ-ын тогтоол       | Зөрүү               |
|    |                                          | 1                    | 2                    | 3                    | 4=3-2               |
| 1  | Аймгийн ИТХ                              | 196 240,30           | 196 117,98           | 343 817,80           | 147 699,82          |
| 2  | Аймгийн ЗДТГ                             | 561 669,50           | 595 046,30           | 1 110 576,30         | 515 530,00          |
| 3  | Сумын ИТХ                                | 1 037 553,60         | 1 276 150,60         | 625 942,80           | - 650 207,80        |
| 4  | Сумдын ЗДТГ                              | 3 796 095,10         | 4 120 971,50         | 4 230 941,50         | 109 970,00          |
| 5  | Санхүүгийн хяналт, аудитын алба          | 90 846,40            | 104 023,70           | 174 125,50           | 70 101,80           |
| 6  | Орон нутгийн өмчийн алба                 | 98 383,80            | 98 278,80            | 138 447,90           | 40 169,10           |
| 7  | Аймгийн Халамжийн сан                    | 8 137 949,00         | 8 013 654,00         | 8 962 753,20         | 949 099,20          |
| 8  | Ахмадын хороо                            | 46 603,80            | 46 603,80            | 46 603,80            | -                   |
| 9  | Ойн анги                                 | 38 857,40            | 32 692,00            | 40 067,00            | 7 375,00            |
| 10 | Байгаль орчин аялал жуулчлалын газар     | 293 379,70           | 341 910,30           | 367 141,40           | 25 231,10           |
| 11 | Байгаль орчин хамгаалах нөхөн сэргээх за | 841 500,00           | 1 030 510,90         | 1 062 110,90         | 31 600,00           |
| 12 | Хотын нийтийн хүн тээвэр                 | 66 000,00            | 66 000,00            | 66 000,00            | -                   |
| 13 | Хот тохижуулах газар                     | 287 071,10           | 575 329,30           | 955 440,30           | 380 111,00          |
| 14 | Усны татаас                              | 64 000,00            | 64 000,00            | 60 000,00            | - 4 000,00          |
| 15 | Мал эмнэлэгийн үйлчилгээ                 | 270 000,00           | 270 000,00           | 60 000,00            | - 210 000,00        |
| 16 | Замын сан                                | 285 120,00           | 270 000,00           | 311 490,00           | 41 490,00           |
| 17 | Ахмадын чөлөөт цагын төв                 | 25 726,00            | 25 468,70            | 26 400,00            | 931,30              |
| 18 | Жолоочийн хариуцлагын даатгал            | 32 000,00            | 30 000,00            | 34 610,00            | 4 610,00            |
|    | <b>Нийт дүн</b>                          | <b>16 168 995,70</b> | <b>17 156 757,88</b> | <b>18 616 468,40</b> | <b>1 459 710,52</b> |

#### 1.2.1. Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн талаар:



## **Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны төсвийн гүйцэтгэл**

Дорнод аймагт орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2018 онд хэрэгжүүлэхээр нийт 57 төсөл арга хэмжээ батлагдсан байна.

Дорнод аймгийн хэмжээнд 2018 оны орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх төсөл, арга хэмжээ нь аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдаж, батлагдсан байх ёстой.

Аймгийн 2018 оны хөрөнгө оруулалтад тусгагдсан нийт 57 төсөл арга хэмжээнээс дараах 6 төсөл, арга хэмжээ нь дээрх баримт бичгүүдэд тусгагдаагүй байна. Үүнд:

- Биеийн тамир, спортын газарт бадминтоны дэвжээ худалдан авах /9,0 сая төгрөг/
- Хөгжим, техник хэрэгсэл /Хилийн 0132-р анги 6,8 сая төгрөг/
- Соёл мэдээллийн төвийн багаж, тоног төхөөрөмж /Зэвсэгт хүчний 327-р анги 20,0 сая төгрөг/
- Аймгийн МХГ-ын Хавирга боомт дахь ажилчдын байр /20,0 сая төгрөг/
- Авто тээврийн үндэсний төвийн Дорнод аймаг дахь салбарын тавилга, хэрэгсэл /5,0 сая төгрөг/
- Цагаан-Овоо сумын халуун усны барилгын ажилд дэмжлэг /30,0 сая төгрөг/
- Сумын эрүүл мэндийн төвийн барилгын тоосгон хаяавчтай төмөр сараалжин хашааг шинээр хийх /Хөлөнбуйр 30,0 сая/
- Чойбалсан нисэх онгоцны буудлын зочид хүлээн авах танхимын засварт дэмжлэг /20,0 сая/

Сумдын хөрөнгө оруулалтаар 2018 онд 1468,3 сая төгрөгийг баталснаас сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, сумын эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдаагүй дараах ажлууд байна. Үүнд:

- Матад сум 8 төсөл, арга хэмжээ /59,7 сая төгрөг/
- Булган сум 1 төсөл, арга хэмжээ /10,0 сая төгрөг/
- Хэрлэн сум 3 төсөл, арга хэмжээ /613,0 сая төгрөг/
- Баян-Уул сум 3 төсөл, арга хэмжээ /11,3 сая төгрөг/
- Дашбалбар сум 1 төсөл, арга хэмжээ /3,0 сая төгрөг/
- Халхгол сум 1 төсөл, арга хэмжээ /17,0 сая төгрөг/

Аймаг, сумдын хувьд төсөвт байгууллага болон холбогдох газруудаас ирүүлсэн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээний саналыг хурлаар хэлэлцэж ач холбогдлоор нь эрэмбэлж хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон эсэх нь баримтаар нотлогдохгүй байгаа бөгөөд төлөвлөлтийн талаар судалгаа шинжилгээ хийсэн баримт материал байхгүй байна.

### **1.2.2. ОНХС-гийн төлөвлөлтийн талаар:**

Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хуулиар ОНХС-гаас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 3,650.4 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгаас сумдад олгохоор төлөвлөсөн ОНХС-ийн шилжүүлгийг Засгийн газрын 2017 оны 230 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлгийг тооцох аргачлал”-ын дагуу хуваарилсан эсэхийг үзэхэд суманд 41.3 хувь



## Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны төсвийн гүйцэтгэл

буюу 1,630.5 сая төгрөг, аймагт 58.6 хувь буюу 2,313.2 сая төгрөгийг хуваарилж олгосон нь хуульд заасан 30-аас доошгүй хувийг хуваарилах гэсэнд нийцэж байгаа хэдий ч хүн амын тоо, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээг харгалзан хийх хуваарилалтыг 84.8 сая төгрөгөөр зөрүүтэй тооцон төлөвлөсөн байна.

### Хүснэгт 5. ОНХС-гаас сумдад хуваарилахаар төлөвлөсөн санхүүжилтийн тооцооллын зөрүү

/мян.төг/

| Сумдын нэр      | хүн ам            | Алслалт           | ГНХ               | олговол зохих       | олгохоор тогтсон    | Зөрүү       |
|-----------------|-------------------|-------------------|-------------------|---------------------|---------------------|-------------|
| Баяндун         | 24 663,27         | 46 410,31         | 24 684,18         | 95 757,76           | 98 706,20           | - 2 948,44  |
| Баянтүмэн       | 19 749,63         | 3 164,34          | 32 930,71         | 55 844,68           | 63 343,70           | - 7 499,02  |
| Булган          | 15 271,89         | 14 766,92         | 28 143,16         | 58 181,96           | 47 902,00           | 10 279,96   |
| Гурванзагал     | 11 253,80         | 35 598,82         | 20 783,93         | 67 636,55           | 52 175,70           | 15 460,85   |
| Дашбалбар       | 27 254,81         | 47 465,09         | 34 483,69         | 109 203,59          | 109 671,50          | - 467,91    |
| Матад           | 26 731,75         | 38 235,77         | 90 358,01         | 155 325,52          | 172 857,60          | - 17 532,08 |
| Халхгол         | 24 790,07         | 89 656,28         | 111 181,91        | 225 628,26          | 249 712,90          | - 24 084,64 |
| Хөлөнбуйр       | 14 812,22         | 33 752,95         | 14 932,56         | 63 497,74           | 46 879,00           | 16 618,74   |
| Сэргэлэн        | 15 580,97         | 18 458,65         | 16 500,58         | 50 540,19           | 44 791,20           | 5 748,99    |
| Цагаан-Овоо     | 28 594,17         | 31 643,39         | 25 732,56         | 85 970,12           | 86 729,90           | - 759,78    |
| Баян-Уул        | 36 947,35         | 50 102,04         | 22 253,00         | 109 302,39          | 130 733,50          | - 21 431,11 |
| Чойбалсан       | 21 730,94         | 14 503,22         | 40 178,33         | 76 412,49           | 86 537,30           | - 10 124,81 |
| Чулуунхороот    | 14 637,87         | 65 396,34         | 25 880,18         | 105 914,39          | 79 550,10           | 26 364,29   |
| Хэрлэн          | 370 186,74        | -                 | 1 111,30          | 371 298,05          | 360 923,10          | 10 374,95   |
| <b>Нийт дүн</b> | <b>652 205,48</b> | <b>489 154,11</b> | <b>489 154,11</b> | <b>1 630 513,70</b> | <b>1 630 513,70</b> |             |

Аймгийн ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх иргэдийн санал аваагүй нийт 154,1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээг төлөвлөж баталсан байна. Үүнд:

- Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, эрх нь зөрчигдсөн хүүхэд, эмэгтэйчүүдийг түр хамгаалах байрны, хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн “Хүүхэд хөгжлийн төв”-д дэмжлэг үзүүлэхэд 10.0 сая
- “Аз жаргал” төвийн үйл ажиллагаанд дэмжлэгт 5.0 сая
- Тэжээлийн доройтолтой болон суурь өвчлөлтэй хүүхдүүдийг хүүхдийн зуслан, сувилал түшиглэн асарч, сувилах төсөл 24.5 сая
- “Хүн болох багаасаа” дэд хөтөлбөрт 5.0 сая
- “Гэр бүлийн хөгжил дэвшил” /2018-2020 он/ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 10.0
- Хүүхдэд ээлтэй засаглал 2020 хөтөлбөрт 10.0 сая
- Халдварт өвчнөөс сэргийлэх хянах үндэсний хөтөлбөрт 10.0 сая
- Хүний хөгжлийг хангах, хөгжлийн индексийг дээшлүүлэх, аймгийн эдийн засаг, нийгэм, хүний хөгжлийн төлөө хөтөлбөрт 79.6 сая төгрөг

Сумын иргэд олон нийтийн саналыг аваагүй, эрэмбэлсэн жагсаалтад тусгагдаагүй ажлуудад 6,2 сая төгрөгийг төлөвлөж баталсан байна. Үүнд:

- Матад суманд фитнес байр тохижуулахад 1,2 сая төгрөг, Задгай талбайн тайзны засвар хийхэд 1,5 сая төгрөг,
- Дашбалбар суманд ахмадын байрны халаалтын зуух хийхэд 1,5 сая төгрөг,
- Булган суманд цэцэрлэгт гэр худалдан авахад 2,0 сая төгрөг

Энэ нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6 , 63 дугаар зүйлийн 63.2 “Энэ хуулийн 63.1-д заасан санал болон баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг иргэдийн Нийтийн Хурал хэлэлцэн, тэргүүлэх ач холбогдол бүхий төсөл, арга хэмжээг эрэмбэлэн сонгоно.” гэсэн заалтад нийцэхгүй байна.

Хөлөнбуйр сумын орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 27,9 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд шилжүүлэн



## Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны төсвийн гүйцэтгэл

зарцуулахаар төлөвлөсөн байна.

Төрийн аудитын газраас төсвийн төслийг Төсвийн тухай хуульд заасан зарчим, шаардлагад нийцүүлэхгүй 1.1 тэрбум төгрөгийн зардлыг бууруулах тухай саналаас 446.4 сая төгрөгийн зардлыг бууруулах санал хүргүүлснийг хүлээн авч тусгасан байна.

### II Бүлэг. Төсвийн гүйцэтгэлийн үр дүн хангалтгүй байна.

**2.1. Аймгийн төсвийн 2018 оны нийт орлого хэрэгжсэн боловч тусламжийн орлого 61,3 хувиар тасарсан байна.**

Дорнод аймгийн 2018 оны төсвийн орлого 62,093.5 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 63,629.4 сая төгрөг буюу 2.4 хувиар давж биелсэн

| Үзүүлэлт                                 | Нийт         |               | Зөрүү       |
|------------------------------------------|--------------|---------------|-------------|
|                                          | төлөвлөгөө   | Гүйцэтгэл     |             |
| НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН            | 62,093,508.0 | 63,629,742.6  | 1,472,287.6 |
| НИЙТ ОРЛОГО                              | 18,066,758.0 | 19,953,743.7  | 1,886,985.7 |
| а.Урсгал орлого                          | 18,066,758.0 | 19,953,743.7  | 1,886,985.7 |
| ТАТВАРЫН ОРЛОГО                          | 16,861,458.0 | 17,948,669.0  | 1,087,211.0 |
| Орлогын албан татвар                     | 10,064,956.1 | 10,604,475.1  | 539,519.0   |
| ХАОАТ                                    |              |               | -           |
| Цалин хөлсний орлогын албан татвар       | 9,806,956.1  | 10,140,861.50 | 333,905.4   |
| ХАОАТ-ын буцаалт                         | - 910,000.0  | - 877,049.60  | 32,950.4    |
| Шүүд бус орлого /суутгагч 10/            | 712,000.0    | 818,533.60    | 106,533.6   |
| Үйл ажиллагааны орлого /хувиараа ААН эр  | 450,000.0    | 515,532.40    | 65,532.4    |
| Бусад татвар                             | 6,000.0      | 6,597.20      | 597.2       |
| Өмчийн татвар                            | 987,600.0    | 722,873.0     | - 264,727.0 |
| Үл хөдлөх хөрөнгийн албан татвар         | 600,000.0    | 601,862.20    | 1,862.2     |
| Бууны албан татвар                       | 387,600.0    | 43,839.30     | - 343,760.7 |
| Бусад                                    |              | 77,171.50     | 77,171.5    |
| Тусгай зориулалтын орлого                | 367,027.7    | 368,218.5     | 1,190.8     |
| Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсли | 367,027.7    | 368,218.50    | 1,190.8     |
| Бусад татвар                             | 5,808,901.9  | 6,621,320.9   | 812,419.0   |
| УТХ                                      | 1,503,126.6  | 1,015,911.60  | - 487,215.0 |
| Газрын төлбөр                            | 410,000.0    | 482,747.10    | 72,747.1    |
| Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигла  | 298,000.0    | 100,175.20    | - 197,824.8 |
| Нохойны албан татвар                     | 500.0        |               | - 500.0     |
| Бусад татвар хураамж                     | 2,500.0      | 8,910.00      | 6,410.0     |
| Газрын дуудлага худалдаа                 | 57,108.8     | 157,894.10    | 100,785.3   |
| Хог хаягдлын үйлчилгээний хураамж        | 260,647.4    | 273,196.40    | 12,549.0    |
| Бусад                                    |              | 878,492.30    | 878,492.3   |
| Байгалийн нөөц ашигласны төлбөр          | 3,277,019.1  | 3,703,994.2   | 426,975.1   |
| Ус, рашааны нөөц ашигласны төлбөр        | 3,234,730.0  | 3,637,549.00  | 402,819.0   |
| Ойн нөөц ашигласны төлбөр                | 35,000.0     | 35,642.70     | 642.7       |
| Ан амьтны нөөц ашигласны төлбөр          | 7,289.1      | 30,802.50     | 23,513.4    |
| ТАТВАРЫН БУС ОРЛОГО                      | 1,145,300.0  | 1,560,944.7   | 415,644.7   |
| хүүгийн орлого                           | 75,640.0     | 179,181.70    | 103,541.7   |
| Торгуулийн орлого                        | 943,560.0    | 990,128.10    | 46,568.1    |
| Түрээсийн орлого                         | -            | 2,811.20      | 2,811.2     |
| Бусад орлого                             | 126,100.0    | 388,823.70    | 262,723.7   |
| ХӨРӨНГИЙН ОРЛОГО                         | 60,000.0     | 75,911.5      | 15,911.5    |
| хөрөнгө худалдсаны орлого                | 60,000.0     | 75,911.50     | 15,911.5    |
| ТУСЛАМЖИЙН ОРЛОГО                        | 44,026,750.0 | 43,675,998.9  | - 350,751.1 |
| Оны эхний үлдэгдлээс санхүүжих /ОНЕО/    | 3,248,688.5  | 3,248,688.5   | -           |
| Оны эхний үлдэгдлээс санхүүжих /ОНХС/    | 39,354.7     | 39,354.7      | -           |
| Оны эхний Сүм хөгжүүлэх сан              | 153,199.7    | 153,199.7     | -           |
| Сүм хөгжүүлэх сан                        | 776,710.5    | 753,125.2     | - 23,585.3  |
| Аймгаас авсан санхүүгийн дэмжлэг         | 4,591,080.3  | 4,591,080.3   | -           |
| ОНХСангийн шилжүүлэг                     | 3,650,421.8  | 3,650,421.8   | -           |
| БХСан оны эхний үлдэгдлээс               | 39,367.9     |               | - 39,367.9  |
| БХСан                                    | 3,825.0      |               | - 3,825.0   |
| Аймгийн төсөвт төвлөрүүлсэн              | 270,000.0    | 270,000.0     | -           |
| ТУСЛАМЖИЙН ОРЛОГО                        |              |               | -           |
| Тусгай зориулалтын шилжүүлэг             | 30,488,689.6 | 30,442,004.8  | - 46,684.8  |
| Өөрийн орлого ОНТБ                       |              | 78,906.4      | 78,906.4    |
| Өөрийн орлого ТЗШБ                       | 85,454.0     | 66,567.2      | - 18,886.8  |
| Туслах                                   | 679,958.0    | 382,650.3     | - 297,307.7 |



**Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн  
2018 оны төсвийн гүйцэтгэл**

байна.

Төсвийн орлого батлагдсан төлөвлөгөөнөөс 1,472.2 сая төгрөгөөр буюу 2.5 хувиар давж биелнээс татварын орлого 572.3 сая төгрөгөөр, татварын бус орлого 894.4 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Татварын орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь авч үзвэл:

- Татварын орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл доорх 3 төрөл тасарснаас бусад төрлийн татварууд 100,0-422,6 хүртэл хувиар давж биелсэн байна.
- Төсвийн тухай хуулийн 23.4.9 дахь заалтын дагуу улсын төсвийн орлогын бүрэлдэхүүнд хамаарах улсын тэмдэгтийн хураамжийн 1.0 тэрбум төгрөгөөс Хэрлэн сумын төсөвт төвлөрүүлэхээр төлөвлөсөн нь 523.0 сая төгрөгөөр тасарсан байна.
- Газрын дуудлага худалдааны орлого 100.7 сая төгрөгөөр тасарсан нь төлөвлөгдөн газруудын дуудлага худалдаа амжилтгүй болсонтой холбоотой байна.
- Баяндун сум нохойны албан татварт 500.0 мянган төгрөгийн орлого төлөвлөсөн боловч огт хэрэгжээгүй нь тооцоо судалгаа, үндэслэлгүй төлөвлөсөнтэй холбоотой байна.

Татварын бус орлогын гүйцэтгэлийг нэр төрлөөр нь авч үзвэл:

- Улсын төсвөөс олгох шилжүүлгийн орлогын 38,730.2 сая төгрөг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрсөн байна.
- Арилжааны банкин дахь хадгаламжийн хүүгийн орлого 421.1 сая төгрөг, хүү торгуулийн орлого 573.9 сая төгрөгөөр тус тус давж биелсэн нь Хувь хүний орлогын албан татварын хуулийн зарим заалт болон зөрчлийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотой байна.
- Байгуулсан албан ёсны гэрээ хэлцэлгүйгээр газрын тосны хайгуул олборлолт эрхлэх зөвшөөрөл бүхий 5 аж ахуйн нэгжээс авахаар төлөвлөсөн хандив, тусламжийн орлого 464,2 сая төгрөг буюу 61,3 хувиар тасарсан байна.

**2.2. Төсвийн нийт зардлыг 185,4 сая төгрөгөөр хэмнэсэн байна.**

Аймгийн төсвийн нийт зарлага жилийн эцсийн байдлаар 62,235.2 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 60,269.0 сая төгрөгийн буюу 96.8 хувийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд хөрөнгийн болон сангуудын үлдэгдлийг хасахад бодит хэмнэлт 185,4 сая төгрөг байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар нийт зардал 60,269.0 сая төгрөгийн гүйцэтгэл байгаа бөгөөд 51,982.5 сая төгрөг буюу 86.2 хувийг урсгал зардалд, 7,934.3 сая төгрөг буюу 13.2 хувийг хөрөнгийн зардалд, 352.2 сая төгрөг буюу 0.6 хувийг эргэн төлөгдөх зээл олголтод зарцуулсан байна.

Хүснэгт 7. 2018 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг харуулбал:

/сая.төг/

| Үзүүлэлт                                 | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү   | Хувь  |
|------------------------------------------|------------|-----------|---------|-------|
| <b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b> | 62,235.2   | 60,269.0  | 1,966.1 | 96.8  |
| <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>                     | 52,620.1   | 51,982.5  | 637.5   | 98.8  |
| <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>   | 40,595.2   | 40,003.8  | 591.4   | 98.5  |
| <b>ТАТААС</b>                            | 835.2      | 835.2     | 0       | 100.0 |
| <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>                  | 11,189.6   | 11,143.4  | 46.1    | 99.6  |
| <b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>                  | 8,700.9    | 7,934.3   | 766.6   | 91.2  |



**Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн  
2018 оны төсвийн гүйцэтгэл**

|                     |       |       |       |      |
|---------------------|-------|-------|-------|------|
| ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЗЭЭЛ | 914.1 | 352.1 | 562.0 | 38.5 |
|---------------------|-------|-------|-------|------|


Зардлын гүйцэтгэлийг бүлгээр авч үзвэл 185,4 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Орон нутгийн төсвийн нийт зарлага 31,681.6 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 29,787.3 сая төгрөгийг зарцуулж, 1,894.3 сая төгрөгийг орон нутгийн ерөнхий орлогын дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад 30,553.6 сая төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 30,481.6 сая төгрөгийг зарцуулж, 72.0 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хувь хүний орлогын албан татварын буцаан олголтыг төрлөөр нь харуулбал:

график – 2



Буцаан олголтоос 32.9 сая төгрөг хэмнэгдсэн нь орон сууцны ипотекийн зээл зогссон, иргэдийн орон сууцны худалдан авалт буурсантай холбоотой байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-гийн хөрөнгийн зарцуулалтын талаар:

- Төсвийн тухай хуулийн 6.6.6-д “тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй, тухайн шатны төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй 673,7 сая төгрөгийн 7 арга хэмжээний хөрөнгө оруулалт болон төсөл арга хэмжээг, мөн хуулийн 4.1.24 дэх “хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг” хэлнэ гэсэн заалтуудтай нийцэхгүй 34,6 сая төгрөгийн 10 хөрөнгө оруулалтын бус зардлыг хөрөнгө оруулалтаас төлөвлөж зарцуулсан байна.
- Сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн ажлуудад гүйцэтгэл гараагүй байхад санхүүжилт олгосон, төрийн чиг үүрэгт хамаарахгүй, тухайн шатны захирагч нь өөрийн бүрэн эрхэд хамаарахгүй ажлуудыг төлөвлөж хэрэгжүүлэн санхүүжилт олгосон 82,5 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ байна.



- Мөн Халхгол сумын Засаг даргын Тамгын газар нь 2018 онд автомашин, цахим худгийн тоног төхөөрөмжийг худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль, журмыг баримтлаагүй, үнэлгээний хороо байгуулаагүй, гэрээ байгуулаагүй үед 32,0 сая төгрөгийг шилжүүлсэн, хөрөнгийг одоог хүртэл хүлээн аваагүй, мөн гэрээний нөхцөлүүд стандартын шаардлагыг хангаагүй, Хэрлэн сум Засаг даргын Тамгын газар нь сумын хөрөнгө оруулалтын зардлаас тухайн шатны төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй “Зан заншил, ёслол хүндэтгэлийн өргөө байгуулах” засварын зардалд 41,9 төгрөгийг “Данриг данжаалан хийд” ТББ-ын үйл ажиллагааны дэмжлэгт, Дашбалбар сумын Засаг даргын Тамгын газар нь хөрөнгө оруулалтын зардлаас тухайн шатны төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй, хөрөнгө оруулалтын бус шинжтэй гандангийн дээврийн засварын ажилд 3,0 төгрөгийг тус тус зарцуулсан нь төсвийн тухай хуулийн 6.4.2, 41.2.6 заалтуудыг зөрчсөн байна.
- Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”, 60.3.5-д “зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах”, Сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 7.4 дэх заалтад нийцэхгүй 3 арга хэмжээнд 58,2 сая төгрөгийг зарцуулсан байна.
- Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудад 886,8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох журмын дагуу зохион байгуулаагүй байна.
- Баяндун сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 3000,0 мянган төгрөгийн төсөвтэй “Халуун усны засвар”-ын ажлын төсвөөс 1500,0 мянган төгрөгийг батлагдсан арга хэмжээнд зарцуулалгүй Наранбулаг хөгжил ОНӨААТҮГ-ын урьд оны өрийг төлсөн байна.
- Хөлөнбуйр сум нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 27,9 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд шилжүүлэн зарцуулсан байна.

### **2.3. Төсвийг зарцуулахдаа Төсвийн болон ТБОНӨХБАҮХА тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.**

Төсвийн тухай хуулийн 6.6.6-д *“тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх”* гэсэн заалттай нийцэхгүй, тухайн шатны төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй 673,7 сая төгрөгийн 7 арга хэмжээний хөрөнгө оруулалт болон төсөл арга хэмжээг, мөн хуулийн 4.1.24 дэх *“хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг”* хэлнэ гэсэн заалтуудтай нийцэхгүй 34,6 сая төгрөгийн 10 хөрөнгө оруулалтын бус зардлыг хөрөнгө оруулалтаас төлөвлөж зарцуулсан байна.

Сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн ажлуудад гүйцэтгэл гараагүй байхад санхүүжилт олгосон, төрийн чиг үүрэгт хамаарахгүй, тухайн шатны захирагч нь өөрийн бүрэн эрхэд хамаарахгүй ажлуудыг төлөвлөж хэрэгжүүлэн санхүүжилт олгосон 82,5 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээ байна.

Мөн Халхгол сумын Засаг даргын Тамгын газар нь 2018 онд автомашин, цахим худгийн тоног төхөөрөмжийг худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа хууль, журмыг баримтлаагүй, үнэлгээний хороо байгуулаагүй, гэрээ байгуулаагүй үед 32,0 сая төгрөгийг шилжүүлсэн, хөрөнгийг одоог хүртэл хүлээн аваагүй, мөн гэрээний нөхцөлүүд стандартын шаардлагыг хангаагүй, Хэрлэн сум Засаг даргын Тамгын газар нь сумын хөрөнгө оруулалтын зардлаас тухайн шатны төсвөөр



**Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн  
2018 оны төсвийн гүйцэтгэл**

хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй “Зан заншил, ёслол хүндэтгэлийн өргөө байгуулах” засварын зардалд 41,9 төгрөгийг “Данриг данжаалан хийд” ТББ-ын үйл ажиллагааны дэмжлэгт, Дашбалбар сумын Засаг даргын Тамгын газар нь хөрөнгө оруулалтын зардлаас тухайн шатны төсвөөр хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй, хөрөнгө оруулалтын бус шинжтэй гандангийн дээврийн засварын ажилд 3,0 төгрөгийг тус тус зарцуулсан нь төсвийн тухай хуулийн 6.4.2, 41.2.6 заалтуудыг зөрчсөн байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”, 60.3.5-д “зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авах”, Сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн зааврын 7.4 дэх заалтад нийцэхгүй 3 арга хэмжээнд 58,2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудад 886,8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох журмын дагуу зохион байгуулаагүй байна.

Баяндун сумын ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 3000,0 мянган төгрөгийн төсөвтэй “Халуун усны засвар”-ын ажлын төсвөөс 1500,0 мянган төгрөгийг батлагдсан арга хэмжээнд зарцуулалгүй Наранбулаг хөгжил ОНӨААТҮГ-ын урьд оны өрийг төлсөн байна.

Хөлөнбуйр сум нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 27,9 сая төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд шилжүүлэн зарцуулсан байна.

**2.4. Нэмэлт төсвийг захиран зарцуулахдаа төсвийн тухай хууль болон холбогдох хууль журмыг мөрдөн ажиллаагүй байна.**

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад харьяалагдах төсвийн байгууллагуудын нэмэлт орлогын дансанд 3115,9 сая төгрөгийн орлого дараах эх үүсвэрүүдээс орсон. Үүнд:

- ✓ Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 164,0 сая төгрөг
- ✓ Засгийн газрын нөөц сан, Засаг даргын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөр 326,4 сая төгрөг
- ✓ Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөр 2044,4 сая төгрөг
- ✓ Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогоор 581,1 сая төгрөг.

Тайлант онд ТЕЗ-ийн эрхлэх хүрээний байгууллагууд 3,115.9 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч 2,930.5 сая төгрөгийг зарцуулж 185.4 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.



**Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн  
2018 оны төсвийн гүйцэтгэл**

**Хүснэгт 8. Нэмэлт санхүүжилтийн орлого, зардлын гүйцэтгэл:**

/сая төг/

| Нэмэлт орлогын дансны дүн | Орлогын дүн    | ОУ-ын байгууллагаас авсан хандив тусламж | Дотоодын байгууллагаас авсан хандив, тусламж | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс | Төсвийн ерөнхийлөн захирагчдаас хуваарилсан мөнгө | Бусад эх үүсвэрээс хуваарилсан мөнгө | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | Зарцуулалт     | Нийт төвлөрүүлсэн |
|---------------------------|----------------|------------------------------------------|----------------------------------------------|-------------------------------------------------------------------------------|---------------------------------------------------|--------------------------------------|------------------------------------------------------------------------------|----------------|-------------------|
| <b>Нийт</b>               | <b>3,115.9</b> | <b>33.8</b>                              | <b>130.1</b>                                 | <b>326.3</b>                                                                  | <b>1,433.9</b>                                    | <b>610.5</b>                         | <b>581.1</b>                                                                 | <b>2,930.5</b> | <b>185.4</b>      |

Сангийн сайдын 2017 оны 216 тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих” журмын 4 дүгээр бүлгийн 4.1 дэх хэсэгт “Төсвийн шууд захирагч нь төсвийн төвлөрүүлэн захирагчид, төсвийн төвлөрүүлэн захирагч нь төсвийн ерөнхийлөн захирагчид, төсвийн ерөнхийлөн захирагч нь Сангийн яаманд төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах хүсэлтийг энэ журамд заасны дагуу тооцож, холбогдох бусад мэдээллийн хамт хүргүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлэн ажиллахгүй байна.

Иймд ТТЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайлангаар “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих” журмыг хэрэгжилтийг ханган ажиллах талаар албан шаардлагыг төсвийн төвлөрүүлэн захирагч нарт хүргүүлэн ажилласан.

Мөн Төсвийн төвлөрүүлэн захирагчдын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17.3 дахь хэсэгт “Албан тушаалтан хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байна”, Төсвийн тухай хуулийн 25.2 дахь хэсэгт “Зөвхөн дор дурдсан нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төсвийн байгууллага энэ хуульд заасан журмын дагуу хандив, тусламж авч болно” гэсэн заалтуудыг зөрчин 35.5 сая төгрөгийн хандив авч зарцуулсан Баяндун, Хөлөнбуйр, Булган сумдын Засаг дарга нарыг АТГ-т шалгуулахаар шилжүүлсэн. /Баяндун сумын Засаг дарга 27.5 сая, Хөлөнбуйр сумын Засаг дарга 6.0 сая, Булган сумын Засаг дарга 2.0 сая/

### **III Бүлэг. Тухайн жилд хүрэх зорилтот түвшин бүрэн хангагдаагүй байна.**

#### **3.1. ТЕЗ-ийн хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн биелэлтийг бүрэн дүгнэх боломжгүй байна.**

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч **жилийн төсвийн гүйцэтгэл**, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 01-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлэхээр заасан. Мөн хуулийн 54.5-д заасан төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн болох хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулгыг аудит хийх хугацаанд бүрэн гаргаж ирүүлсэнгүй.



**Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн  
2018 оны төсвийн гүйцэтгэл**

ТЕЗ нь Төсвийн тухай хуулийн 31.1.2 болон “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 7 дугаар зүйлийн 7.5.6 дахь заалтын дагуу хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг төсвийн захирагч бүрээр төлөвлөж батлуулаагүй байна.

Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь Дорнод аймгийн Засаг даргын тамгын газрын 2018 оны үйл ажиллагаанд ерөнхий үнэлгээ хийж 86.3 хувьтай дүгнэсэн байна.

Уг үнэлгээнд ТЕЗ-ийн хэрэгжүүлэх бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн дундаж хувь 83.9 байгаагаас хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг 94.1 хувь, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн тухайн оны хэрэгжилтийг 73,9 хувь, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн тухайн оны хэрэгжилтийг 64,9 хувь, аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг 95.3 хувь, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн үнэлгээг 91.2 хувьтай дүгнэсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас жил бүр давтан хийгддэг санхүү болон гүйцэтгэл, нийцлийн аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн дүн өмнөх оноос буураагүй байгаа бөгөөд нийт алдаа зөрчлийн дүн 6,167.9 сая төгрөг буюу 195.9 хувиар өссөн байна.

**Хүснэгт 8. Алдаа зөрчлийг өмнөх онтой харьцуулбал:**

*сая.төг*

| Үзүүлэлт                             | Санхүүгийн тайлангийн аудитаар |                 | Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт |                 | ОНХС          |               |
|--------------------------------------|--------------------------------|-----------------|---------------------------------------|-----------------|---------------|---------------|
|                                      | 2017                           | 2018            | 2017                                  | 2018            | 2017          | 2018          |
| Төлбөрийн акт                        | -                              | -               | -                                     | 76,90           | 5,40          | 123,50        |
| Зөрчил арилгах албан шаардлага       | -                              | -               | 12,00                                 | 842,60          | 49,10         | 351,70        |
| Хариуцлага тооцуулах албан шаардлага | -                              | -               | -                                     | -               | -             | 27,90         |
| Зөвлөмж                              | 1 624,20                       | 5 101,10        | 866,50                                | 2 632,60        | 591,50        | 160,30        |
| <b>Нийт зөрчил</b>                   | <b>1 624,20</b>                | <b>5 101,10</b> | <b>878,50</b>                         | <b>3 552,10</b> | <b>646,00</b> | <b>663,40</b> |

Энэ нь Төсвийн захирагч нарын хууль тогтоомжийн дагуу хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн, хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх дүн зорилтот түвшинд хүрэхгүй байгааг харуулж байна.

Аудитын хугацаанд Төсвийн тухай хуулийн 54.5.4-т заасан танилцуулга /хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/-ыг ирүүлэхийг мэдэгдсэн ч 2019 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийг хүртэл ирүүлээгүй.

Иймд ТЕЗ-ийн хэрэгжүүлсэн хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн биелэлтийг бүрэн дүгнэх боломжгүй байна.



### **3.2. Хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналт хийгдээгүй байна.**

ТЕЗ-ийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд тавих дотоод хяналт нь Төсвийн тухай хуулийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна”, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор батлагдсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5.2.4-т “төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилт, зарцуулалт, түүний үр ашгийн байдалд хяналт тавих”, 8.5-д “Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн ерөнхийлөн захирагчийн болон бусад төсвийн захирагчдын дотоод аудитын үйл ажиллагаанд дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартын дагуу чанарын хяналтын үнэлгээг 2 жилд 1 удаа хийнэ” гэсэн заалтуудаар тус тус зохицуулагдаж байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, Төсвийн ерөнхийлөн захирагчийг эрсдэлийг удирдлагаар хангах чиг үүргийнхээ дагуу 2018 оны төсвийн төсөлд зөвлөмж өгч ажилласан байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд хяналт шалгалтыг 2018 оны ажлын төлөвлөгөөндөө 11 дүгээр сарын 25-наас ажлын 30 хоногт буюу 2019 оны 01 дүгээр сарын 04-ны дотор багтаан хийхээр ТЕЗ-аар батлуулсан боловч уг хяналт шалгалтын ажлын тайлан, дүгнэлт одоог болтол эцэслэн дуусгаагүй байна. Жич: Санхүүгийн хяналт, аудитын албаны 2019.03.22-ны 55 тоот тайлбарыг хавсаргав.

### **ДҮГНЭЛТ**

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Аймгийн 2018 оны төсвийг үр дүнтэй төлөвлөөгүй байна.
2. Төсвийн гүйцэтгэлийн үр дүн хангалтгүй байна.
3. Тухайн жилд хүрэх зорилтот түвшин бүрэн хангагдаагүй байна.



## **ЗӨВЛӨМЖ**

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

### **Аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн-д**

1. Төсвийг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах.
2. ТЕЗ-ийн хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга /хөтөлбөрийн гүйцэтгэлийн биелэлт, бодлогын зорилтын хэрэгжилт, түүний үр нөлөөнд хийсэн дүгнэлт, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний биелэлт, тасарсан бол шалтгаан/-ыг төсвийн тухай хуулийн 8.9.4-д заасан хугацаанд гарган ирүүлж байх.
3. Төсвийг зарцуулахдаа Төсвийн болон ТБОНӨХБАҮХА тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж ажиллах
4. Нэмэлт төсвийг захиран зарцуулахдаа төсвийн тухай хууль болон холбогдох хууль журмыг мөрдөн ажиллах
5. ТЕЗ-ийн хэрэгжүүлсэн хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналтын үр нөлөөг сайжруулахад анхаарах.
6. Төрийн аудитын байгууллага, түүний ажилтнууд бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах аливаа мэдээллийг шуурхай бүрэн хэмжээгээр, саадгүй гаргаж өгч байх.

Аудитаар тавигдсан төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг хангуулж 2019 оны 11 дүгээр сарын 10-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.



**Дорнод аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн  
2018 оны төсвийн гүйцэтгэл**



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА  
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2019 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 14

Чойбалсан хот

Г  
Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны төсвийн  
гүйцэтгэлийн тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13.5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2018 оны А/207 дугаар тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, 2016 оны А/92 тоот тушаалаар батлагдсан "Гүйцэтгэлийн аудитын журам"-ын 12.40 дэх заалт, аймаг дахь Төрийн аудитын газрын удирдлагын зөвлөлийн 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ нь:

1. "Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны төсвийн гүйцэтгэл"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталсугай.
2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, аймгийн Засаг дарга М.Бадамсүрэн нарт тус тус хүргүүлсүгэй.
3. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ахлах аудитор /Д.Нармандах/-д даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.БАТБАЯР

110419027